

ТОКСОПЛАЗМОЗ (Toxoplasmosis A58)

Тодорхойлолт:

Коксод эгэл биетнээр үүсгэгдэх өвчин. Халдвар ихэвчлэн шинж тэмдэггүй явагдана.

Үүсгэгч

Toxoplasma gondii бөгөөд эс доторхи 4-7 мкм хэмжээтэй шимэгч паразит.

Тархалт:

Дэлхий даяар тархсан. Өмнөд болон хойд Америк, зүүн өмнөд Ази (Хятад, Солонгос), Европ (Англи, Ирланд, Португал, Франц, Испани), шинэ Зеландад тархсан.

Резервуар :

180 гаруй төрлийн гэрийн болон зэрлэг сүүн тэжээлтэн (муур, нохой, чандага, араатан амьтад, өвсөн идэшт мэрэгчид).


Халдвар дамжих зам:

Ахуй хавьтлын замаар буюу хүүхдүүд халдвартай муур, нохой байсан тоглоомын талбай, хашаанд, элсэн дээр тоглох үедээ халдвартай ооцистыг залгиж, халдвар авдаг.

Хоол хүнсний замаар буюу цист бүхий халдвартай махыг (гахай, хонь, заримдаа үхийн мах) түүхийгээр буюу дутуу болгож хэрэглэх болон халдвартай ооцист бүхий ус, хүнсийг ууж, идснээр халдвар авна.

Ховор тохиолдолд ооцист амьсгалын замд орсон тохиолдол бий.

Мөн эхсээр дамжин ураг халдварлана. Халдвартай донороос цус сэлбэх, эрхтэн шилжүүлэн суулгахад халдвар дамжиж болно.



Зураг: Токсоплазмоз өвчний дамжин тархах зам

Нууц үе 20-23 хоног байна.

Халдвартай байх үе:

Өвчтэй эхсээр урагт халдвар дамжиж болно. Муурын баасаар ялгарсан ооцист нь спор үүсгэн, 1-5 хоногийн дараа халдвартай болж, ус, чийгтэй хөрсөнд 1 жил гаруй хугацаанд халдвартай байдлаа хадгалдаг.

Мэдрэг хүн ам:

Бүх хүн ам мэдрэг боловч дархлаа хурдан тогтдог, халдвар ихэвчлэн шинж тэмдэггүй явагдана. Дархлал дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа ХДХВ-ын халдвартай өвчтөнүүдэд халдвар дахин идэвхжиж, өвчлөл үүсгэх эрсдэл их байдаг.

Лабораторийн шинжилгээнд сорьц цуглуулах, шинжлэх

Токсоплазмозын сэжигтэй өвчтнөөс цус, ийлдэс, нугасны шингэн, ургийн ус, цогцосноос зүрх, дэлүүний сорьц авна. Ариун нөхцлийг ханган сорьцыг цуглуулах ба сорьц тус бүрийг бүрэн хаягласан байвал зохино. Сорьц материалыг 2-8 хэмд хадгалах бөгөөд 3 савлагааны зарчмыг баримтлан тээвэрлэж, хатаахгүй, халаахгүйгээр яаралтай лабораторид хүргэх хэрэгтэй. Мөн сорьцыг тээвэрлэхдээ мөсөн элемент хэрэглэх ба сорьцыг асгарсан тохиолдолд шингээх боломжтой шингээгч материал бүхий хуванцар саванд байршуулж, лабораторид хүргүүлнэ.

Цуглуулсан сорьц материалыг ийлдэс судлал, молекул биологийн аргаар шинжилнэ.

Халдварын хяналт

А. Сэргийлэх арга хэмжээ:

1. Махыг сайтар чанаж хэрэглэх
2. Жирэмсэн эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар зааж сургах ба муурны хэвтрийг цэвэрлэхдээ бээлий өмсч, гарын ариун цэврийг сахих
3. Өдөр бүр муурын баасыг хаяж, хэвтрийг цэвэрлэж байх хэрэгтэй.
4. Түүхий мах, муурын баасаар бохирдсон хөрсөнд хүрсний дараа, хоол идэхийн өмнө гараа угааж байх хэрэгтэй.
5. Тэнэмэл муурыг хяналтанд авах, тэднийг хүүхэд тоглодог элснээс хол байлгах. Хэрэглээгүй үедээ элсийг хучиж хамгаалах нь зүйтэй.

Б. Халдвар хамгааллын арга хэмжээ:

1. Мэдээлэх:
2. Тусгаарлах: шаардлагагүй.
3. Явцын халдваргүйтгэл: шаардлагагүй.
4. Хөл хорио: шаардлагагүй.
5. Хавьтлыг дархлаажуулах: шаардлагагүй.
6. Хавьтал болон халдварын эх уурхайг тогтоох: Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүдийн эсрэг биеийн титрыг тодорхойлж, муурын баас, хөрс, түүхий мах эсвэл угаагаагүй ногоо зэрэг халдварын нэг эх үүсвэр байгаа эсэхийг судална.
7. Эмчилгээ: Шинж тэмдгийн эмчилгээ хийнэ.